

Гадаадын иргэдийн боловсролыг дүгнэх нь

Гадаадын иргэдийн ангилал нь Боловсролын Акт ба Залуучууд, Спорт, Боловсролын Яамнаас (MEYS) гаргасан арга барилын удирдамжийн дагуу явагддаг. Гадаадын иргэдийн хүүхдүүдийг дүгнэж байхдаа “Чех хэл ба чех уран зохиол” хичээлд чех хэлний мэдлэгийн түвшинг харгалзаж үзэх шаардлагатай.

Чех улсаас өөр улсын харъяалалтай иргэдийн хүүхдүүд болон Чех улсын ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн боловсролын дүнг Боловсролын Актын 51-ээс 53 хүртэлх Хэсгүүд ба ерөнхий боловсролын сургуульд суралцах 14-өөс 17 Тогтоолын дагуу дүгнэдэг.

Сурагчдыг дүгнэхдээ 15(2) Хэсэг ба Тогтоолын (4) хэсэгт заасны дагуу Чех улсад чех хэлний мэдлэгийн түвшин нь сурагчийн ур чадварт маш том үүрэг гүйцэтгэхдэг болохыг харгалзана. Сурагчдын боловсролын нэг хэсэг болох Ерөнхий Боловсролын Хөтөлбөрийн хүрээгээр тодорхойлсон (эсвэл “Чех хэл ба чех уран зохиол” бага сургуулийн одоогийн боловсролын хөтөлбөрөөр тооцсон) “Чех хэл ба чех уран зохиол”-ын агуулгаар шалгаж байхад Чех улсын сургуулийн гурван хагас жилийн эцэст чех хэлний мэдлэгийн түвшин нь 15(2) Хэсэг ба Тогтоолын (4) хэсэгт заасан нөхцөл байдлын дагуу хүүхдийн ур чадвар, чармайлт, сургалтад гол чухалчлах үүрэг гүйцэтгэж, зайлшгүй хэсэг болдог байна.

Эхний хагас жилийн эцэст гадаад харъяалалтай сурагчдыг сургуулийн тайлагналын шалгалтанд орох огноо нь гарсан ч гэсэн шалгалт өгч дүгнэгдэггүй. Гэхдээ хэрэв тус сурагч нь хичээлийн хоёрдугаар хагас жилийн эцэст дүгнэгдээгүй бол тэр уг хичээлийн жилдээ дахин давтаж сурах хэрэгтэй.

Словак улсын иргэд хичээл сургалтын үеэр “Чех хэл ба чех уран зохиол” хичээлээс бусад хичээлийг словак хэлээр сурах эрхтэй.